



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 618

Улаанбаатар хот

Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713” төслийн хүрээнд бий болсон нийт 10,498,545,070.27 (арван тэрбум дөрвөн зуун ерэн найман сая таван зуун дөчин таван мянга далан төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг холбогдох өр төлбөрийн хамт Булган аймгийн өмчид бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Зээлийн хөрөнгөөр бий болсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2.Үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших эрхийг холбогдох орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

123006621

32-r huraldaan.docx


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР "ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН МОН-3713" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ (ТОВЧОО)

Д/д	Хөрөнгийн нэр	Нийт дүн (төгрөг)	Хүлээн авч бүртгэх орон нутгийн өмчит байгууллага	Сангийн яам, аймгийн Засаг даргатай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний огноо
1	Булган аймгийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	9,971,826,080.69	Булган аймгийн өмчит байгууллага (100%)	2019.08.29
2	Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	526,718,989.58		
Нийт дүн		10,498,545,070.27		
		(арван тэрбум дөрвөн зуун ерэн найман сая таван зуун дөчин таван мянга далан төгрөг хорин долоон мөнгө)		